

Илтгэх хуудсын бүтэц, онцлог, агуулгын
уялдаа холбоог мэдэх

VII анги

Хичээлийн зорилго

- Илтгэх хуудсыг уншиж зорилго, гол санаа, баримтыг ялгах
- Илтгэх хуудас бичвэрийн онцлогийг мэдэх
- Загварт найруулгын тухай ойлголтыг мэдэж авах

Үйл ажиллагаа 1.

1. Дараах илтгэх хуудаст хэн, хэнд, юуны тухай, яах гэж, яасан гэсэн асуулт тавьж уншъя

Хэн ?	→	Багш Б.Цогзолмаа
Хэнд ?	→	Сургуулийн захиргаанд
Юуны тухай?	→	"Номын баяр" аян явуулсан тухай
Яах гэж ?	→	Сурагчдыг номтой нөхөрлүүлэх , ном унших хэрэгцээ сонирхлыг нэмэгдүүлэх
Яасан ?	→	Эцэг эхчүүдийг татан оролцуулсан, эсээ бичлэгийн уралдаан ... үр дүнтэй... болжээ.

Байгууллагын нэр
Гарчиг
Огноо
.....дүүргийн сургууль
Илтгэх хуудас
"Номын баяр" сарын аян явуулсан тухай
2013 оны 03 дүгээр сарын 20
Улаанбаатар хот
Баримт бичгийн нэр
Үйлдсэн газар
Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2012 оны А/51 дүгээр тушаалаар батлагдсан өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, ном унших хэрэгцээ сонирхлыг нэмэгдүүлэх танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй "Ном" хөтөлбөрийн хүрээнд 2013 оны 02 сарын 20-ноос 03 дугаар сарын 20 –ны хооронд тус сургуульд "Номын баяр" сарын аян зохион байгууллаа.
Аянаар эцэг, эхчүүдийг хүүхдийн ном бүтээх бүтээлч ажилд оролцуулах, хүүхдэд зориулсан бүтээлийн сантай болгох зорилгоор ном зохиох уралдаан, "Ном миний хөгжлийн гарц" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, "Ухаан далай номоос эхтэй" сургалт сурталчилгааг зохион байгуулж, ангийн номын сантай болох хөдөлгөөн өрнүүлэн 50 бүлгийн 1759 хүүхэд 1000 гаруй номтой номын сантай боллоо.
Аяны хугацаанд Монголын шилдэг зохиолч, яруу найрагчдын хоёр удаагийн уулзалтаар 4 зохиолчийг урьж, уулзалт, ярилцлага зохион байгуулж давхардсан тоогоор нийт 300 хүүхэд оролцсон байна. .
"Номын баяр" аяныг "Боловсрол телевиз", "Утга зохиол" сонин дэмжин оролцож мэдээлэл хийн, тусгай нэвтрүүлэг бэлтгэж "Ном" хөтөлбөрийг сурталчиллаа.
"Номын баяр" аян төлөвлөсний дагуу үр дүнтэй боллоо.
Хянасан: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР(Д.Намсрай)
ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН БАГШ.....(Б. Цогзолмаа)
Бичвэр
ГАРЫН ҮСЭГ

Үйл ажиллагаа 1 – ээс харахад

Илтгэх хуудас :

- Хэн нэгэн албан ажилтан аливаа үйл явдал, бодит байдлын үнэн зөвийг нотлох зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулсан баримт бичиг юм гэж хэлж болохоор байна.

Үйл ажиллагаа 2. Илтгэх хуудсын бүтэц дараалал, уялдаа холбоог задлая

<p>Эхлэл хэсэгт юуны тухай байна вэ?</p>	<p style="text-align: center;">Юунд үндэслэн, хэзээ, ямар зорилгоор юу хийсэн бэ?</p> <ul style="list-style-type: none">• Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2012 ны А\51 дүгээр тушаалаар батлагдсан “Ном “хөтөлбөрийн хүрээнд• 2013 оны 02 сарын 20-ноос 03 дугаар сарын 20 –ны хооронд• Өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, ном унших хэрэгцээ сонирхлыг нэмэгдүүлэх танин мэдэхүйг хөгжүүлэх зорилготой.• “Номын баяр” сарын аян зохион байгуулсан .
<p>Гол хэсэгт юуг өгүүлсэн байна вэ?</p>	<p style="text-align: center;">Зорилгын хүрээнд юу юу хийв?</p> <ul style="list-style-type: none">• Аянаар эцэг, эхчүүдийг хүүхдийн ном бүтээх бүтээлч ажилд оролцуулсан• Хүүхдэд зориулсан бүтээлийн сантай болгох зорилгоор ном зохиох уралдаан зохион байгуулсан• “Ном миний хөгжлийн гарц” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан• “Ухаан далай номоос эхтэй” сургалт сурталчилгааг зохион байгуулсан• Ангийн номын сантай болох хөдөлгөөн өрнүүлсэн• Зохиолч, яруу найрагчдын хоёр удаагийн уулзалт, ярилцлага зохион байгуулсан
<p>Төгсгөл хэсэгт юуны байна вэ?</p>	<p style="text-align: center;">Ямар үр дүнд хүрсэн бэ?</p> <ul style="list-style-type: none">• 50 бүлгийн 1759 хүүхэд 1000 гаруй номтой номын сантай болсон.• Зохиолч уншигчдын уулзалтад давхардсан тоогоор нийт 300 хүүхэд оролцсон .• “Номын баяр” аяныг “Боловсрол телевиз”, “Утга зохиол” сонин дэмжин оролцож мэдээлэл хийн, тусгай нэвтрүүлэг бэлтгэж “Ном” хөтөлбөрийг сурталчилсан байна.• Аян төлөвлөсний дагуу үр дүнтэй болсон гэж дүгнэсэн.

Эхийн уялдаа холбоог шинжилбэл

- “Номын баяр” сарын аян явуулсан тухай илтгэх хуудсын үндэслэл, зорилго нь тодорхой, баримтад тулгуурласан, тогтсон загварын дагуу тоочин бичжээ.
- Гол хэсгийн цогцолбор тус бүр эхлэл хэсэгтэйгээ “ аянаар” “ аяны хугацаанд” гэсэн үгээр холбогдсон байна.
- Төгсгөл хэсэг нь эхлэл болон гол хэсэгтэйгээ “ Номын баяр” аян гэсэн үгээр холбогджээ.

Илтгэх хуудас

Байгууллагын нэр

Сурагчийн хөгжлийн төв

Баримт бичгийн нэр

ИЛТГЭХ ХУУДАС

Тэргүү буюу гарчиг

Клуб ажиллуулах тухай

Үйлдсэн газар

2014 оны 02 дүгээр сарын 27

Огноо

Эрдэнэдалай сум

5-р ангийн сурагчдаас авсан судалгаанд үндэслэн тэднийг сонирхлынх нь дагуу клубын зохион байгуулалтаар хамтран суралцах, ажил зохион байгуулахаар шийдсэн юм. Энэ ажлыг хийхийн тулд бид цахим хуудас, мэдээллийн хэрэгсэл, сонин зэргийг ашиглан ямар ямар чиглэлээр клуб ажиллуулж болохыг судалж үзлээ. Сурагчдаас авсан судалгаа, цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлан дараах чиглэлүүдээр клуб ажиллуулахаар шийдвэрлэсэн юм. Үүнд:

- Тогтсон загвараар бичсэн.
- Үнэлэмж хандлага илрээгүй.
- Баримтад тулгуурлан бичсэн.
- Үйл явдлыг бүрэн илтгэн тоочсон.
- Үйл хөдлөлийн орон цагийг тоочсон.
- Тооны нэр хэрэглэсэн.
- Үг шууд утгаар байна.
- Товч тодорхой
- Албаны хэрэгцээнд

1. "Намайг дэмжээрэй"

2. "Болно, Болохгүй"

3. "Зохион бүтээгч"

4. "Сонирхогч"

5. "Алдартны бага нас" зэрэг болно. Эдгээр клубт хамрагдах сурагчдыг хуваарилж 3 сарын 1-ээс үйл ажиллагаагаа эхлэхээр боллоо.

ХЯНАСАН: КЛУБИЙН АХЛАГЧ.....(Б.Ирмүүн)

БИЧСЭН: 7-Р АНГИЙН "ИРЭЭДҮЙ" КЛУБИЙН ГИШҮҮН СУРАГЧ (З.Баттөр)

Илтгэх хуудас бичих нь:

Тухайн байгууллага, ажлын хэсэг, ажилтан нь хийсэн ажлынхаа тухай товч мэдээллийг нотолгоо баримтаар батлан, уг ажлыг хийх болсон үндэслэл шалтгаанаа оруулан, дүгнэж бичдэг.

Илтгэх хуудсын гарчиг нь цаасны дээд талаас 20 мм зайд голлож байрлах бөгөөд агуулга нь товч, хураангуй байна.

- Илтгэх хуудсыг хэн?, хэнд? юуны тухай? , яах гэж? яаж? гэсэн асуултад хариулагдахаар бичнэ.
- Баримтад үндэслэн, товч тодорхой бичнэ.
- Цаг хугацаа нь тодорхой дараалалтай байна.
- Үйл явдлыг зэрэгцүүлэн тоочиж бичнэ.
- Үг үсгийн болон хэл найруулгын алдаагүй байх

Загварт найруулгын ойлголт

Монгол хэлний найруулгын төрөл

Албан бичгийн найруулга

Загварт найруулга

Эрдэм шинжилгээний найруулга

Уран зохиолын найруулга

Загварт бус найруулга

Сонин нийтлэлийн найруулга

Төр ба хүмүүс хоорондын, улс хоорондын албан байгууллага хоорондын, хувь хүмүүс хоорондын нийгмийн ба иргэний харилцааны гэх мэт чухал, албан харилцааг зохицуулж байдаг эрх зүйн баримт бичиг байдаг.

Албан бичиг нь

Албан баримт бичгийн хэвлэмэл хуудсыг цагаан буюу цайвар өнгийн цаасан дээр бэлтгэнэ. Баримт бичгийн хэвлэмэл хуудсанд байрлуулахдаа бичвэрийн талбай нь цаасны зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм, дээд захаас 20 мм, доод захаас 20 мм-ээс доошгүй байхаар тохируулна.

Загварт гэсний учир юу вэ?

- Албан бичгийн найруулга нь тогтсон стандарт, хэв загварыг баримталдаг.
- Баримт үнэн зөв, баримт бичгийг үйлдсэн болон хянасан, зөвшөөрсөн хүний гарын үсэг, нэр хаяг, огноог зөв бичсэн байх
- Үгийг шууд утгаар хэрэглэдэг.
- Хувь хүний сэтгэл хөдлөлийн өнгө аяс илэрдэггүй.
- Зөв зохистой найруулгатай байх

Дүгнэх нь

- Танилцуулга , илтгэх хуудас нь зорилго ,зориулалт, бүтэц зохиомж, бичлэгийн хувьд ялгаатай боловч албан бичгийн найруулгад тавигдах шаардлага, ерөнхий зарчим нь ижил бичвэр юм.

Анхаарал тавьсанд баярлалаа